

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/11

Арвайхээр

Сүрьеэгийн үзлэг, шинжилгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засгын газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.4 дэх заалт, Глобаль сан, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Эрүүл мэндийн газартай байгуулсан 2021-2023 онд хамтран ажиллах гурвалсан гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүрьеэтэй өвчтөний хавьтлыг үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, зардлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийн дагуу үзлэг, шинжилгээг зохион байгуулж зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, ерхийн эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа), Захиргаа аж ахуй нийтлэг үйлчилгээний албаны дарга, ерөнхий санхүүч (Б.Валя)-д тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

18900 027

ЭМГ-ын даргын 2021 оны 04-р сарын 04
- ны өдрийн 4/4 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



“СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ ХАВЬТЛЫГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД
ХАМРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Арвайхээр

2021-04-20

Үндэслэл: 2020 оны жилын эцсийн байдлаар улсын хэмжээнд сүрьеэ өвчний 3339 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 10%-ийг эзэлж байна. Нийт өвчлөлийн 1261 тохиолдол буюу 38,4% нь аймаг орон нутагт бүртгэгдэж байна.

Өвөрхангай аймагт 2020 онд сүрьеэгийн 56 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Нийт өвчлөлийн 64,2% нь суманд бүртгэгдсэн байна. 2020 онд 18 сумаас 151 үйлчлүүлэгчийн 302 сорьцыг тээвэрлэснээс Сант, Гучин-Ус сумаас түрхэц эерэг 2 тохиолдлыг илрүүлэн 100% эмчилгээнд хамруулан ажилласан байна.

2021-2023 онд Глобаль сан, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газрийн гурвалсан гэрээг байгуулж, энэхүү хугацаанд сүрьеэгийн хавьтлыг урьдчилан сэргийлэх үзлэг, сүрьеэгийн сорьцыг тээвэрлэх ажлыг эрчимжүүлж, өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх, хянах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зорилго: Сүрьеэгийн тохиолдлын хавьтлыг хянах, үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх

Зорилт:

1. Сүрьеэгийн тохиолдлын хавьтлыг үзлэг, шинжилгээнд хамруулж, сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
2. Ард иргэдэд ухуулга сургалт сурталчилгааг зохион байгуулах

Хугацаа: 2021 оны 04-р сарын 15-ноос 5-р сарын 15-ныг хүртэл

Хамрах хүрээ: БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв

Зохион байгуулах үйл ажиллагаа:

Зорилт-1-ийн хүрээнд:

- 2.1. Сүрьеэгийн халдварт өндөр эрсдэлтэй хүн амыг сүрьеэгийн идэвхтэй үзлэгт хамруулж, сэжигтэй тохиолдлоос цэрний шинжилгээг авч, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансерт хүргэх
- 2.2. Сүүлийн 2 жилд сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн хавьтлыг үзлэгт бүрэн хамруулж, сэжигтэй тохиолдлоос цэрний шинжилгээ авах
- 2.3. Сорьц тээвэрлэлтэнд дүгнэлт хийж, сорьц тээвэрлэх журмын хэрэгжилтийг эрчимжүүлэн сард 1-2 удаа сорьц тээвэрлэлтийг зохион байгуулах
- 2.4. Түрхэц эерэг сүрьеэ, хүүхдийн сүрьеэ, олон эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн өвчтний ар гэр, ойрын хавьтлыг 100 хувь хяналтанд оруулах

- 2.5. Сүрьеэгийн хавьтагсад болон эрсдэлт бүлгийн хүн амын дархлааг сайжруулах ажлыг зохион байгуулах

Зорилт 2-ын хүрээнд:

- 2.1. Сүрьеэ эдгэрдэг өвчин, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
- 2.2. Сайн дурын идэвхтэнд сургалт зохион байгуулж, тэдгээрээр дамжуулан ард иргэдэд ухуулга сурталчилгааг хүргэх
- 2.3. Сүрьеэ эдгэрдэг өвчин, сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхахгүй байх, хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас хэвлүүлж, байгууллага, аж ахуй нэгж, олон нийтийн үйлчилгээний газрууд, банк санхүүгийн байгууллагуудад байршуулж, иргэдэд сурталчлах
- 2.4. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар сүрьеэгийн чиглэлээр сурталчилгаа явуулах
- 2.5. Хэвтэн эмчлүүлэгч нарт Сүрьеэ болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэ өвчний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- 2.6. БОЭТ-ийн амбулаторийн үйлчлүүлэгч нарт сургалтын телевизороор мэдээлэл сурталчилгаа хийх

Үр дүн: Сүрьеэгийн тохиолдлын хавьтлыгүзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг эрт илрүүлж, хяналтад авсан байна.

ЭМГ-ын даргын 2021 оны 8-р сарын 24
 - ны өдрийн А/Н дугаар тушаалын
 хоёрдугаар хавсралт



СҮРБЕЭГИЙН ХАВЬТЛЫГ ИЛРҮҮЛЭХ, ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭНД
 ХАМРУУЛАХАД ОЛГОЖ БУЙ ШАТАХУУН, ТОМИЛОЛТЫН
 ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	Сум, өрхийн нэр	2019 он	2020 он	2021 оны эхний 3 сар	Нийт хяналтад байгаа өвчтөний тоо	Эм татан авах шатахууны тооцоо	Хавьтлыг үзлэг шинжилгээнд хамруулахад эмч, вакцины сувилагч, жолоочод олгох томилолтын зардал	Нийт олгох зардал
1	Баруунбаян-Улаан	1	4		5		72000	72000
2	Бат-Өлзий	1	1		2		36000	36000
3	Баянгол	4	2		6		72000	72000
4	Баян-Өндөр	1	0		1		36000	36000
5	Богд	2	0	1	3	126000	144000	270000
6	Бүрд	1	0		1		36000	36000
7	Гучин-Ус	0	0		0			
8	Есөнзүйл	1	2	1	4	60000	144000	204000
9	Зүүнбаян-Улаан	0	2		2		36000	36000
10	Нарийнтээл	0	0		0			
11	Өлзийт	0	0		0			
12	Сант	1	3		4		72000	72000
13	Тарагт	1	2		3		72000	72000
14	Төгрөг	2	1		3		72000	72000
15	Уянга	7	2	1	10	36000	252000	288000
16	Хайрхандулаан	1	2		3		36000	36000
17	Хархорин	4	5	1	10	78000	252000	330000
18	Хужирт	2	3	1	6	54000	252000	306000
19	Уянсэтгэл	11	6		17		252238	252238
20	Түшигдөлгөөн	7	3		10		180000	180000
21	Нарныдөш	11	8		19		252238	252238
21	Нийт	58	46		104	354000	2268475	2622475